

үгүйсгэхгүй.

Орчин үед улсын хил хяналтын байгууллага, гаалийн байгууллагын хамтын ажиллгааны хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах, гадаад оронтой харилцан ашигтай хамтран ажиллах гэх мэт нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.

"Гаалийн хил" тогтоосноор тэнд гаалийн хууль тогтоомж үйлчлэх хүрээ бий болж, ингэснээрээ бараа тээврийн хэрэгсэл, зорчигчдын хувийн хэрэглээний эд зүйлс, гаалийн хяналт шалгалт хийж, гаалийн татвар тариф ноогдуулан гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх гэх мэт олон талтай үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Гаалийн хилд хийх хяналт шалгалтыг бодвол улсын хилийн хяналт шалгалт өргөн хүрээтэй онцгой чухал хяналт байдаг. Гаалийн хилийг зөвхөн гаалийн хяналт шалгалт хийх зорилгоор байгуулж байдгаараа өвөрмөц онцлогтой.

Өнөөдөр хилийн боомтод ажиллах албадын хамтын ажиллагааг боловсронгуй болгох, тэнд ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах тэдгээртэй холбоотой хууль эрх зүйн орчинг бүрдүүлж тусгаар улсыхаа хил хамгаалалтад иргэн бүрийг оролцуулах нь Монгол Улсын төрийн бодлогын нэг чухал зорилго мөн.

*

*

*

Хил, гааль судлагчдад тусламж

1925 оны Гаалийн архив сөхвөөс...

Хил, гааль хоёр ажиллах объект, үйл ажиллагааны зорилго, харилцах субъект зэрэг олон талаараа ялангуяа хилийн асуудлар олон жилийн туршид хамтран ажиллаж иржээ. 1925 оны үест зөвхөн Хөвсгөлийн хойд хил дээр гааль, гаалийн түшмэд ямар чухал үүрэг гүйцэтгэж байсныг товч авч үзье.

Энэ үед Ханхын гааль, Хантайшир уулын аймгийн Жаргалан уулын сумын гааль, Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошууны гааль, Хатгал дах гааль, түрээсний хороо, Хантайшир уулын аймгийн Жаргалан-Уул сумын Сартолгойн гааль, Хантайшир уулын Баянзүрх уулын хошууны гааль, Их шавь Дархад нутгийн гааль, Богд хан уулын Хангай хайрхан уулын хошууны Ар гөрөөчин сумын гааль гэх зэрэг олон газар гааль түрээсийн хороо ажиллаж байжээ.

А/. Гааль зарим онцлог хэрэгт үнэмлэх шийтгэн олгодог байв. 15/ 1925/ оны Цагаан сарын 22-ны өдөр 200 дугаар үнэмлэх бичиг шийтгэн

олгосны учир эдүгээ Их шавийн Зуны голын отгийн дарга Ширэндэв, харъяат гаалийн хорооны хашаа байшинг бүрнээ зөөж, Хөвсгөл далайн хоолойд худалдаалан суугаа орос Сибиррайсоузын пүүсний ойр газар буулгахаар хэлэлцэн, уг зүйлийн тээвэр зэргийн хөлс гурван зуун гучин гурван лангаар тогтож нэгэнт завсраа харилцан хэлэлцэж зөвшөөрсөн учир ийнхүү бат итгэмжлэх гэрээ мэт үнэмлэх бичиг хадгалуулсан,... сүүл дор гарын үсэг зурж батлагдсан тул ийнхүү үнэмлэх бичиг олгов гэжээ.

Дээрх үнэмлэхээс ажиглахад Хатгалын гаалийн байшинг Зуны голоос зөөж, Далайн хоолойд барьсан тэнд нь Сибирийн худалдааны пүүс байсан тэдэнтэй ойр байх нь гаалийн ажилд дөхөмтэй байсан, эд хогшлын зүйлдээ Тээврийн гэрээ хэмээх иргэний хуулийн гэрээний нэгэн төрлийг иргэний хууль гараагүй үед ч мөрдөж байсан зэрэг нь сонирхолтой юм.

Гаалийн ажилтныг төрийн захиргааны төв байгууллага томилдог байжээ. 15 оны нэгдүгээр сарын 20-ны бичгийн агуулгыг үзвэл Сангийн Явдлын Яамнаас 698 тоот бичгээр томилогдсон 7 цагдаагийн дотроос цагдаа Буниа, Туншиг, Ёндоншарав нар бие барсан буюу өвчин тохиолдсон тул бие хамгаалах тэмдэгт хуудсыг хураан бичгийн дугтуйд агуулж Монгол Улсын Ардын Засгийн Сангийн Явдлын Яамнаа өргөн мэдүүлжээ. Тунгаан үзвээс хөдөөгийн гаалийн цагдааг Сангийн Яам томилж, бие хамгаалдаг үнэмлэх олгодог, халагдах, нас барах тохиолдолд хураан авч Сангийн Яаманд хүргүүлдэг хатуу журам байжээ.

Сангийн Яам гадаадад гарах, оруулах бараанд үнэ тогтоож гаалийн хорооддоо мэдээлдэг. 1915 оны 2-р сарын 14-ний өдөр. Сангийн Яам худалдааны зарим бараа юмны үнийг бага бага хувьсгажээ. Үүнд: Сайн үнэг 16 төг, муу нь 10 төг, хярсны арьс 8, мануулын арьс 6, сайн хэрэм 1 төг 60 мөн, муу нь 60 мөн, хонины арьс 1 төг 10 мөн, намрын тарваганы сайн арьс 1 төг 70 мөн, байхуу цай сайн хүнз 70 төг, цагаан цууянбуу толгой бүр нь 12 төгрөг гэх мэт 36 зүйлийг жагсаажээ.

Ханхын гаалийн түшмэл, Сартолгойн гаалийн түшмэл зэрэг газарт гааль хураах, дотоод гадаадын тэмдэгт хуудас тус бүр зууг хүргүүлсэн баримт байна.

Зуны голын Гаалийн хорооны дэргэд 25 хүүхэдтэй бага сургууль байгуулж 15 дугаар оны намрын тэргүүн сарын шинийн нэгнээс 16 дугаар оны 4-р сарын 30-ныг хүртэл арван сард хэрэглэх эр хонь 150-ийг, нэг бүрийг нь 2 лан 80 пүнгээр бодож, бүгд 420 лан мөнгө гаргуулжээ.

Зам явах үнэмлэх бичиг олгох ажил их хийгдэж байв. Жишээ нь Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошууны нутаг Алагцар хэмээх газар оршин суусан буриад Гарам, Мэргэн шанаа хэмээх газар суугаа буриад Жав, буриад Балдан нарын хүмүүс Түнхэн хот орж талх, гурил зэрэг бага бага юм авахыг хүссэнд 30 хоногийн хугацаатай тэмдэг дарсан бичиг олгож, замд тохиолдох гадаад дотоодын аливаа ард түмний түшмэл ардууд учрыг мэдэж найртай сайнаар одох ирэхэд тусламжийг үзүүлэн өнгөрүүлэхийг мэдэгдэж байв.

Гадаадын харьяат нар монгол газар суухыг хүсвэл тэдэнд нэг жилийн хугацаатай бие хамгаалах бичгийг тодорхой он сартайгаар олгож байв. 1914 оны 10-р сарын 11-нээс эхлэн 86 хүнд бие хамгаалах бичиг олгосны дотор Центросоюзын пүүс, Сибиррайсоюзын пүүс, монгол улсын харилцан туслах хоршооны ажлаар Мөрөн, Хатгал, Ханх зэрэг газарт суух албан хаагчид болон худалдааны ажил эрхлэх 29 орос, түүний дотор хэд хэдэн орос эхнэр, Мөрөн, Хатгал, Ханхад сууж худалдаа хийх Дундад улсын иргэн 20 гаруй хятадад бие хамгаалах бичиг олгожээ.

Бас ачаа тээгчдэд 7, 8, 9 дүгээр зэргийн жингийн тэмдэгт бичиг олгож нэгэн лан таван пүнгээс эхлээд 3, 5, 10 лангийн татвар хурааж энэ тухайгаа 57 хүний нэр дээр бүртгэн үйлдсэнийхээ дотор Хантайшир уулын аймгийн Далай гүн, Ахай бэйс зэрэг нутгийн хүмүүс, орос, буриад нарт олгож байжээ.

*МХСҮН-ийн тэргүүлэгч гишүүн,
профессор Со.Бадарчи.*

